



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 179

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Налайхын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 5 нэрийн, нийт 52,473,427.20 (тавин хоёр сая дөрвөн зуун далан гурван мянга дөрвөн зуун хорин долоон төгрөг хорин мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Налайхын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ц.Энхтүвшин нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Тээврийн хэрэгслийг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001188

15-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн
 ..279.... дугаар тогтоолын хавсралт

"НАЛАЙХЫН ДУЛААНЫ СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ
 ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн бүртгэлийн дугаар	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуриутлагдсан элэгдэл (төгрөг)
1	Дизель компрессор	E203000003	1995.01.01	1	ш	1,200,000.00	1,200,000.00
2	Цацран гэр	E203000007	2001.12.01	1	ш	993,700.00	993,700.00
3	Аналитик жин FA-1004	F205000044	2013.09.30	1	ш	1,522,727.20	1,522,727.20
4	T-170 Трактор 20-71 УР улсын дугаар, 148552 арлын дугаар	E2030000007	2001.12.01	1	ш	46,957,000.00	46,957,000.00
5	Халаалтын программ	I211000003	2016.01.01	1	ш	1,800,000.00	1,800,000.00
Нийт дүн				5			52,473,427.20
				(тав)			(тавин хоёр сая дөрвөн зуун далан гурван мянга дөрвөн зуун хорин долоон төгрөг хорин мөнгө)